

ЕРӨНХИЙ САЙД АГДАНБУУГИЙН АМАРЫН ЗХУ-Д
ХИЙСЭН СҮҮЛЧИЙН АЙЛЧЛАЛ

Д.Гомбосүрэн.

Батлан хамгаалахын эрдэм-шинжилгээний хүрээлэн

Өгүүллийн товч утга: Монгол Улсын Ерөнхий сайд Агданбуугийн Амарын Зөвлөлт Холбоот Улсад сүүлчийн удаа хийсэн албан ёсны айлчлалыг хэрхэн бэлтгэж, зөвлөлтийн удирдагчтай хийсэн яриа хэлэлцээ, бүгдийн үр дүнд энэхүү өгүүллийг зориулав.

Түлхүүх үг: айлчлал, хүсэлт, лавлагаа, уулзалт, яриа хэлэлцээ, үр дүн



БНМАУ-ын Ерөнхий сайд бөгөөд гадаад явдлын яамны сайд, Улсыг батлан хамгаалах комиссын дарга Агданбуугийн Амар Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчдийг толгойлж, Зөвлөлт Холбоот Улсад 1936 оны X сарын 28-ны өдрөөс 1937 оны I сарын 14-ны хүртэл хоёр сар хагас хугацаагаар албан ёсны айлчлал хийсэн юм. Энэ бол Монгол төрийн нэрт зүтгэлтэн А.Амарын ЗСБНХУ-д хийсэн сүүлчийн айлчлал байлаа.

Энэхүү айлчлалын мэдээлэл, түүнд хэрхэн бэлтгэсэн хийгээд Ерөнхий сайд А.Амар, Зөвлөлтийн удирдагч нарын албан ёсны уулзалт, хэлэлцээ зэргийг товч өгүүлэхийг зорив.

Айлчлалын товч мэдээлэл. Зөвлөлтийн тухайн үеийн хэвлэлд гарсан мэдээг үндэслэн айлчлалын талаарх ерөнхий

дарааллыг авч үзвэл:

- 1936.X.28. БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлтийн дарга бөгөөд Гадаад хэргийг сайд Амар Москвад хүрэлцэн иржээ.¹ Түүнтэй хамт БНМАУ-д суугаа Бүрэн эрхт төлөөлөгч В.Х.Тайров, Засгийн газрын нарийн бичгийн дарга Өлзий-Онир ЗСБНХУ-д суух Бүрэн эрхт төлөөлөгч (элчин) Дэндэв нар очсон байна. Төлөөлөгчдийг хуучин элчин Л.Дарьзав нар тосон авчээ.²
- 1936.X.29. А.Амарыг Б.С.Стомняков, М.М.Литвинов нар хүлээн авч уулзав.
- 1936.X.30. А.Амар, Мэнд, Л.Дарьзав нар ЗСБНХУ-ын Гадаад судалгааны ардын комиссор Розенгольцтой уулзжээ.
- 1936.X.31. К.Е.Ворошилов, А.Амар, Л.Дарьзав нарыг хүлээн авчээ.
- 1936.XI.03. А.Амар, Л.Дарьзав, Дамба нар ЦДКА (Улаан армийн төв ордонд)-д зочилжээ.
- 1936.XI.04. В.Е.Молотов А.Амарт зоог барив. Монголын талаас: Амар, Мэнд, Дарьзав, Дэндэв, Яндаг, Нанзад, Равдан нар Оросын талаас: Сталин, Кгонович, Ворошилов, Ординеникидзе, Чуборь, Микоян, Ежов, Литвинов, Рзенгольц, Крестинский, Стомоняков, Элава, Томров, Нулляр, Розловакий, Брисов, Мессинг нар байлцжээ.
- 1936.XI.10. Б.Стомоняков Монголын засгийн газрын хүсэлтийг И.В.Сталинд гадуулж өгөв. Тэрбээр Сталинтай уулзаад “Амар Таныг болон Молотов, Ворошилов нарыг хүлээн авна гэдэгт итгэж буй агаад сонирхсон асуудлаараа хэлэлцээ хийж, зөвлөгөө авахыг хүсэж байгаа болно. Энэ нь Монголын чухал асуудлыг хэлэлцээд зогсохгүй, бас Амарын нэр төрийг монголын удирдлагын дотор бэхжүүлэхэд чухал юм³ гэжээ.

¹ “Правда” сонин.29 Октября 1936г. №299.(6905). Цаашид мөн сонины мэдээгээр Зөвлөлтийн талаас угтаж авсан хүний нэр тодорхойгүй.

² Зөвлөлтийн талаас угтаж авсан хүний нэр тодорхойгүй.

³ Д.Гомбосүрэнгийн хувийн цуглуулга

II. МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

- 1936.XI.14. М.И.Калинин БНМАУ-ын шинэ Бүрэн эрхт төлөөлөгч Дэндэвийг хүлээн авав.
- 1936.XII.24. А.Амарыг Сталин Молотов, Ворошилов нар хүлээн авч ярилцжээ.
- 1937.I.04. А.Амарыг Сталин, Молотов, Ворошилов нар хоёр дахиа хүлээн авч ярилцав.
- 1937.I.13. А.Амарыг Ворошилов хүлээн авч ярилцсанаар айлчлал өндөрлөсөн байна.

БНМАУ-ын Ерөнхий сайдын айлчлалын бэлтгэлд холбогдох зарим баримт сэлт

БНМАУ-д суугаа Бүрэн эрхт төлөөлөгч В.Х.Тайровоос ЗСБНХУ-ын Гадаад хэргийн ардын комиссоровын орлогч Б.С.Стомоняковт 1936.VI.13-нд илгээсэн маш нууц зэрэглэлтэй албан тоотод Ерөнхий сайд А.Амарын ЗХУ-д албан айлчлал хийлгэх асуудлыг анх тавьжээ. Тэрбээр бичихдээ: энэ удаа Амарыг Ерөнхий сайдад сонгосон “чимээгүйхэн” болж өнгөрсөн бөгөөд түүнийг Ерөнхий сайдад сонгосоньг тохиолдуулан Москва ч баяр хүрээгүйг тэмдэглээд а) Н.Элиовагийн төлөөлөгчид XI сарын баяр ёслолыг тохиолдуулан Москвад ирүүлэх манай Засгийн газрын албан ёсны урилгыг Н.Амарт өгөх нь зүйтэй юм, б) манай төвийн сонинуудад Амарын гэрэл зураг, түүний намтар болон сүүлийн үед хэлсэн үгнээс нь тавих ямар нэг боломжийг олох хэрэгтэй байна⁴ гэсэн байдаг.

Дээрх саналын дагуу Ерөнхий сайд Амарын ЗХУ-д хийх айлчлалыг зохион байгуулжээ.

БНМАУ-ын Ерөнхий сайд А.Амар надаас Зөвлөлтийн удирдагчдад тавих найман зүйл хүсэлтийг урьдчилан бэлтгэжээ. Үүнд:

- БНМАУ-ын батлан хамгаалах зардал өссөнийг харгалзан цэргийн зардлын нөхвөрийг (дотаци) нэмэгдүүлэх,
- ЗСБНХУ-аас БНМАУ-д зориулж нийлүүлэх бараа таваарыг өргөтгөх, чанарыг нь сайжруулах, зорилт шаардлагатай барааг шинээр бэлтгэх,
- Улаанбаатарын цахилгаан станцад 2500 Риловатай цахилгаан хөдөлгүүр тавьж өгөх, УБ-налайхын хооронд 39-40 км нарийн төмөр зам тавьж өгөх,
- Улаанбаатар-Хөдөөгийн 170 км засмал зам, баруун хязгаарт Цагаан нуураас Рашаант хүртэл замын засвартай өгөх,
- УБ-Хиагтын хооронд тээвэр хийх 100 автомашин нэмж олгох,
- Геологи-хайгуулын экспедиц гаргаж ажиллуулах, юуны урьд алтны хайгуул хийх,
- Арьс өнгөний өвчнийг устгах, мал эмнэлгийн экспедиц ажиллуулах, бэлчээр хортой ургамал, тэрчилэн усны судалгаа явуулах,
- ШУА-ын экспедицийг оруулах зэрэг хүсэлтийг тавьжээ.

Б.Стомоняков Ерөнхий сайд А.Амарын гарын үсэгтэй БНМАУ-ын Засгийн газрын дээрх хүсэлтийг өөрийн тайлбарын хамтаар БХК(б)Н-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга н.Сталинд хүргүүлсэн байна.

Энэ үндсэн дээр Сталин, Молотов Ворошилов нар ба амар нарын хооронд 1936.XII.24, 1937.I.04-нд хоёр удаа яриа хэлэлцээ явагдсан тухай хойно өгүүлнэ.

Хэлэлцээний өмнө БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дарга Амар гэгч хэн болох тухай нэлээд дэлгэрэнгүй лавлагааг (справка) Зөвлөлтийн боловсруулсан байна.⁵ Энэ Амарын улс төрийн бодлого, түүний эцтад, Япон, ЗСБНХУ-ын талаар баримталдаг

⁴ Д.Гомбосүрэнгийн хувийн цуглуулга

⁵ Д.Гомбосүрэнгийн хувийн цуглуулга

II. МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

бодлого, үзэл санааны төлөвшил, боловсрол, иргэншил, зан төлөвийн дэлгэрэнгүй тодорхойлсон байна. Тухайлбал:

- Үндэсний үзэлтэн Хятадыг эсэргүүцэх, Хятад Улсыг монголчуудын “түүхэн дайсан” хэмээн үздэг МАХН-ын Төв Хороог төлөөлж 1925 онд 5 ээлжийн Гоминданы намын товчоо болон Фын Юйсянтай хийсэн хэлэлцээнд оролцсон, Фын Юйсянд туйлаас итгэдэггүй. Хятад улс гүрэн хүчгүй, тарамдуу байх нь Монголд ашигтай хэмээн итгэдэг.
- Японыг бас дайсан гэж үздэг, БНМАУ нь Зөвлөлт холбоот Улсын дамжиггүй бол Солонгос, Манжуур ба Өвөрмонголын нэг адил болох тавилантай хэмээн ойлгодог.
- ЗСБНХУ-ын хувьд үргэлж баттай байдаг гэхдээ монголын түүхий эдэд хэт шунадаг, дотоод хэрэгт оролцож захиран тушаах хандлага гаргадаг хэмээн заримдаа биднийг хардах нь бий.
- Буддагийн шашин шүтдэг, лам байсан хүн,
- Амар нь монголын хэмжээгээр боловсролтой, соёлтой хүн, буддагийн утга зохиол сайн мэднэ. Монгол хэл дээрх болон Хятадын судар-түүхийн монгол орчуулгын ном зохиол их уншсан, европын монгол судлалтай (орчуулгаар) танил, туршлагын шинжлэх ухаан-физик, астрономи зэргийг сонирхдог. Монголын түүхээр ном бичсэн. Чингис хаан бол эдүгээ хүртэл гараагүй үлгэр жишээч эзэн-удирдагч гэж үздэг. Амар ахуй амьдралдаа нүүдлийн хэвшилдээ үнэнчээ нотолж, эсгий гэрт сууж, дээл өмсдөг, нүүдэл суудалд оролцох гэх мэт.
- Амар хагалан бусниулах, бүлэглэх, далд явуулгыг тэвчинэ. Ихэнхдээ өөрт нь огт ашиггүй байсан ч шулуун шударга, хатуу байр суурь баримталдаг. Хувийн амьдралдаа үлгэр жишээч өрхийн тэргүүн, нэр төртэй, хэний ч өмнө бөхөлддөггүй, гэр бүлдээ үнэнч, архи, тамхи огт хэрэглэдэггүй.
- ЗСБНХУ-д хоёр удаа ирж байв. Худалдааны төлөөлөгчдийг тэргүүлж 1925 онд ирэхдээ БНМАУ дахь тухайн үеийн манай худалдааны практик доголдлыг зоримог, ил тод тавьж байв. БНМАУ-ын шинжлэх ухааны хүрээлэнгийн даргын хувьд 1929 онд хоёр дахь удаагаа ирсэн. Оросоор ярихгүй боловч ойлгоно гэх зэргээр тодорхойлжээ.

Ерөнхий сайд А.Амар нараас зөвлөлтийн удирдагчтай хийсэн яриа хэлэлцээ

Эхний ярилцлага. 1936.XII.23(24)-нд А.Амарыг Молотов хүлээн авах үеэр болсон байна. Зөвлөлтийн талаас Сталин Молотов, Ворошилов, Литвинов, Стамоняков, Тойров нар Монголын талаас Амар, Мэнд, Дэндэв нар оролцжээ. Энэ уулзалтаар А.Амар хоёр үндсэн асуудлаар ярилцах санал тавьжээ. Нэгд. БНМАУ-ын Засгийн газраас албан бичгээр өгсөн хүсэлтийн тухай, хоёр улсын дотоод бодлогын асуудлаар зөвлөгөө авахыг хүссэн байна. Ингээд Монгол орны Дотоодыг хамгаалах цэргийг оролцуулан 19.0 мянгад хүрснийг дурьдаад ноднин жил цэргийн зардлын нөхвөр 8 сая төгрөгийг 14 сая болгон нэмэгдүүлэхийг хүсчээ. Мөн өнгөрсөн 1936 онд 38 сая төгрөг Зэвсэгт хүчинд зарцуулсныг нэлээд ирэх 1937 онд хязгаарын цэргийг бэхжүүлэх, ялангуяа Суйюаны чиглэлд энгийн хамгаалалтыг чангатгах бодолтойгоор танилцуулсан байна. Бас Амар бид Москвад хоёр сар боллоо гэдгийг тэмдэглээд асуудлыг хурдан шийдэх хүсэлтэйгээ илэрхийлжээ. Сталин 14 сая төгрөг их байна, харин танай цэргийн зардлын дөрөвний нэг (10 сая төгрөг)-ийг өгч чадна гэснээр ярилцлага дууссан байна.⁶

Хоёр дахь уулзалт. 1937.I.04-нд болов. Монголоос Амар, Мэнд, Дэндэв нар Оросын талаас Сталин, Молотов, Ворошилов, Орджоникидзе, Раганович, Литвинов, Мясниук, Микоян, Розенгельц, Гранько, Стомоняков, Тамров нар оролцжээ.

⁶ Российко Монгольское военное сотрудничество (1911-1946) Сборик документов. часть II Москва-Улан-Үдэ.2008.

Уулзалтын явцад хоёр тал өмнөх яриагаа үргэлжлүүлэн Монгол Улсын 1937 оны цэргийн зардлын замаар хэлэлцэв. Молотов нар МАХЦ-ын нийт төсөв 33 сая төгрөгийн 30 хувь болох 10 сая төгрөгийн Зөвлөлтийн тал гаргах бололцоотой гэв.

Амар: цэргийн төсвийн 1/3 буюу 11 сая төгрөгийн нөхвөр олгохыг хүсчээ. Молотов: БНМАУ-д байрлуулсан манай цэргийн зардалд ихээхэн хөрөнгө зориулж байгааг дурдаад монголын цэргийн зардлын 30 хувиас илүүгүйг гаргаж болохыг хөтлөөд 7 сая төгрөгийг гүйлгээнд нэмж гаргахыг зөвлөсөн байна. Үүгээр яриа хэлэлцээ дуусав.⁷

Төгсөгчдийн ярилцлага. А.Амар 1937.1.13 нд Ворошиловтай уулзаж, айлчлалынхаа дүнгийн талаар ярилцжээ.

А.Амар: Ярианхаа эхэнд түүний айлчлал амжилттай болсоныг тэмдэглээд монголын төлөөлөгчдийн халуун дотно хүлээж авсан явдлыг талархан илэрхийлэв.

К.Ворошилов: - Би таньтай танилцсандаа их баяртай байна. Та бид бүхэнд маш сайхан сэтгэгдэл төрүүллээ. Таныг өөрийн ард түмэн ба сэхээтний дунд өргөн нар хүндтэй, боловсролтой хүн гэдгийг бид мэднэ. Та БНМАУ-даа буцаж өөрийн оронг хүчирхэг, аз жаргалтай сонирхол байсан болгохын төлөө батлан хамгаалах чадварыг нь улам нэмэгдүүлэх, тусгаар тогтнолоо улам бэхжүүлэхийн төлөө, бүх сэхээтэй, бүх үндэстнээрээ өөрийгөө тойрон хүрээлүүлэн, бас Та бидний тусламжтайгаар танай орны тусгаар тогтнол, бүрэн эрх чөлөөнд халдсан дайсныг цохиж чадна гэдэгт бид хатуу итгэж байна гээд цаашид лам нарынхаа тоог цөөрүүлж, хөдөлмөрийн хүний тоог нэмэгдүүлэхийг зөвлөв. Амар, Ворошилов нарын ярилцлагад өвс хадах, худаг ус гаргах, аажмаар улс орны эдийн засгийн дүр төрхийг өөрчлөх, бага багаар аж үйлдвэржүүлэх, нарийн төмөр замаар зогсохгүй бага ч гэсэн өргөн төмөр замтай болох, намын түүхий эд боловсруулах үйлдвэрийг хөдөөд байгуулах зэрэг олон асуудлыг хөнджээ. Мөн ...ба Дотоодын цэргийг бэхжүүлэх, цэргийн албанд 19 настай идэрчүүдийг татах, Монголд Их сургууль байгуулах талаар ч онцлон ярилцав.

Амар: лам нарын асуудлыг монгол орны нөхцөлд эрс шийдэж болохгүй, Манай нөхцлийг европын хантай харицуулж болохгүй. Монгол оронд шашин шүтлэг нь ард олны ахуйтай гүнзгий холбоотой байдаг юм, иймээс аажмаар шийдэх хэрэгтэй гэж онцлон тэмдэглэв.

Цааш нь ЗХУ-ын тусламжтайгаар БНМАУ хүчирхэг орон болж гэдгийг итгэдэг, бас хилийн чандах 3 сая орчим монголчууд эрх чөлөөгөө олоод хүчирхэг нэгдмэл Монгол Улсыг байгуулна гэдэгт итгэдэг гэдгээ илэрхийлжээ.⁸

Энэ цөөхөн баримт нь А.Амар бол өөрийн үзэл бодолдоо үнэнч, түүнийгээ хэний ч өмнө илэрхийлж, тууштай хамгаалж чаддаг монгол төрийн зүтгэлтэн, соён гэгээрүүлэгч, ахмад дипломатч болохыг нотолж байна.

Ийнхүү Амар, Водомитов нарын тэр ярилцлага (2 цаг орчим)-аар БНМАУ-ын Ерөнхий сайд А.Амарын ЗХУ-д хийсэн сүүлчийн айлчлал өндөрлөжээ. Төлөөлөгчид маргааш нь (1937.01.14) эх орондоо буцав.

МАХН-ын Төв Хорооны Тэргүүлэгчдийн 1937.01.25-ны өдрийн хуралдаанаар Ерөнхий сайд А.Амарын Москвад хийсэн хэлэлцээрийн одоогийн тайланг сонсоод айлчлалыг өндөр үнэлэв.

Ерөнхий сайдын ЗХУ-д хийсэн айлчлал тодорхой үр дүнд хүрснийг дараах баримт гэрчлэнэ. Үүнд: ЗХУ-ын Засгийн газраас БНМАУ-д өвс хадах 10 машинт өгсөнийг буцалтгүй тусламж болгон өгсний дээр Улаанбаатар-Алтанбулагийн засмал зам барих ажлыг 1937 онд эхлэх, Налайх-Улаанбаатарын хооронд нарийн төмөр зам байгуулах тухай БНМАУ-ын захиалгыг хүлээн авж тэдгээр барилга байгууламжийг барихад удаан хугацааны зээл олгохоор ЗХУ-ын Засгийн газар шийдвэрлэсэнийг Ерөнхий сайд Амарт мэдэгджээ.

⁷ Там же. С.36.

⁸ Д.Гомбосүрэнгийн хувийн цуглуулга

II. МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

Академич Ж.Болдбаатарын тэмдгэлсээр: “Амар бол монгол төрийн төлөө ухаан шүүж, насыг зарсан, ааль номхон, сэтгэл зөөлөн, чин зориг гайхамшиг, түүх гэгээн, ид хэвнэвт, эрдэм соёлд хичээнгүй төрийн сэцэн билэгт зүтгэлтэн байжээ.”⁹

Хавсралт 1

Нэр дурдагдаж байгаа Монгол, Зөвлөлтийн нам, төрийн зүтгэлтнүүдийн тухай үеийн албан тушаал

Монголын талаас:

Амар Агдамбуугийн (1886-1941) БНМАУ-ын Ерөнхий сайд Гадаад явдлын яамны сайд улсын батлан хамгаалах комиссын дарга.

Өлзий-Очир Чоймбалын (1900-1937) Засгийн газрын нарийн бичгийн дарга

Дэндэв-БНМАУ-ын Бүрэн эрхт төлөөлөгч

Дарьзав Лхамхүүгийн (1891-1937) БНМАУ-аас ЗСБНХУ-д суух бүрэн эрхт төлөөлөгч.

Мэнд Рэнцэнгийн (1901-1941) Худалдаа, аж үйлдвэр, зам тээвэр, харилцан нэвтрэлцэх холбооны яамны сайд

Дамба Готовын (1899-1941) Дотоод явдлын яамны дэд сайд.

Яндаг Дамдингийн (1902-1937) Монголтрансын Ерөнхий хорооны дарга

Нанзад Гомбын (1898-1938) Монголын Эд хэрэглэгчдийн холбооны Ерөнхий хорооны дарга

Равдан Өлзийн (1898-1937) Улсын худалдааны Ерөнхий захирах газрын дарга

Зөвлөлтийн талаас:

Христофорович (1894-1938) ЗСБНХУ-аас БНМАУ-д суугаа Бүрэн эрхт төлөөлөгч

Борис Сниридонович (1882-1941) ЗСБНХУ-ын Гадаад хэргийн ардын Комиссоор орлогч

Лийвинов Махим Максимович (1876-1951) ЗСБНХУ-ын Гадаад хэргийн ардын комиссар

Розенгольц Аркадий Павиович (1889-1938) ЗСБНХУ-ын Гадаад худалдааны ардын комиссар

Ворошилов Климент Ефрелович (1881-1969) ЗСБНХУ-ын Батлан хамгаалах ардын комиссар

Молотов Вячеслав Явихойлович (1890-1986) ЗСБНХУ-ын Ардын Комиссаруудын Зөвлөлтийн дарга

Сталин Иосиф Виссарионович (1879-1953) БХР(8) Н-ын НТИВ Хорооны Ерөнхий Нарийн бичгийн дарга

Рогонович Лазерь Моислевич (1893-1991) БХК(Б)н-ын нарийн бичгийн дарга

Ординеникидзе Григорий Константинович (1886-1937) ЗСБНХУ-ын Хүнд аж үйлдвэрийн ардын комиссар

Микоян Анистас Иваниович (1835-1978) ЗСБНХУ-ын Хүнсний аж үйлдвэрийн ардын комиссар

Ендов Николай Иванович (1895-1940) ЗСБНХУ-ын Дотоод хэргийн ардын комиссар

Эллиава Илалва Зурабович (1883-1937) ЗСБНХУ-ын Хөнгөн аж үйлдвэрийн ардын комиссарын орлогч

⁹ 1.Монгол төрийн сэцэн билэгт зүтгэлтэн Мэндэлсний нь 120 жилийн ойд зориулсан э/ш-ний хурлын эмхтгэл УБ. 2007 22-23 дахь тал

II. МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

Козиовакий Бянедикт Ичнотьевич (1899-1975) ЗСБНХУ-ын ГХАР-ын хэлтсийн эрхлэгч

Борисов Сүүсей Стенанович (1889-1937) ЗСБНХУ-ын Бүх Холбоотын төвийн гүйцэтгэх хорооны дарга

Межлаук Ванерий Ивонович (1893-1938) ЗСБНХУ-ын Улсын төлөвлөгөөний дарга. АРЗ –ийн орлогч дарга

Гринько Григорий Федорович (1980-1938) ЗСБНХУ-ын Сангийн ардын комиссор

Резюме

В статье рассказывается последний визит премьера министра МНР А.Амора в СССР опираясь богатые архивные материалы он анализирует его иселедования и оригинальные выводы о визите премьера министра А.Амора.